

ОЛОН УЛСЫН ЦООХОР ИРВЭС ХАМГААЛАХ СҮЛЖЭЭНИЙ МЭДЭГДЭЛ 2023.09.07

Цоохор ирвэсийг шилжүүлэн суурьшуулах тухайд

Цоохор ирвэсийг (*Panthera uncia*) судалгаа, хамгааллын зорилгоор амьдрах орчноос нь холдуулах нь зохисгүй зүйл ба ийм тохиолдол дэлхийн хэмжээнд аль хэр байдаг нь тодорхойгүй хэвээр байгаа ч цаашид ийм тохиолдлууд гарсаар байх магадлалтай байна. Иймд Олон Улсын Цоохор Ирвэсний Сүлжээ (Snow Leopard Network) нь энэ тохиолдолд ямар арга хэмжээ авч болох талаар саналаа илэрхийлэн МЭДЭГДЭЛ гаргаж байна. Энэ мэдэгдлээрээ зэрлэг амьтны амьдрах орчинд цоохор ирвэсийг судлах, хамгаалах зорилгоор шилжүүлэн суурьшуулахгүй байхыг онцлон тэмдэглэж байна. Харин амьтан өвчилсөн, үлдээх боломжгүй онцгой нөхцөл байдалд барьж зөөвөрлөн амьтан асрах байгууллага, амьтны хүрээлэнд аваачиж болох юм.

Цоохор ирвэс нь Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны (IUCN) улаан жагсаалтад эмзэг ангилалд бүртгэгдэж, цоохор ирвэс бүхий орнуудын үндэсний болон олон улсын хуулиар устах аюулд байгаа зүйл хэмээн үзсэн байдаг. Амьд болон үхсэн амьтад тэдгээрийн эд эрхтний олон улсын худалдаа, тээвэрлэлтийг CITES (Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай конвенц) хянаж, зохицуулдаг. GPS бүхий хүзүүвч зүүх, хөдөлгөөн мэдрэгч камерын урхи, ялгадасны ДНХ-ийн шинжилгээ, ялгадасны микрогистологийн шинжилгээ, зан төрхийн ажиглалт зэрэг олон төрлийн судалгааны аргууд нь энэхүү зүйлийн талаарх шинжлэх ухааны нарийн мэдээллийг өгөхөд чухал ач холбогдлоо өгч байна. Тиймээс ч судалгааны зориулалтаар амьдрах орчинд нь барьж, судалсан бодгалиуд тухайн амьтны физиологи, анатоми, зан төрхийн талаарх гол асуултуудад үнэ цэнэтэй ойлголтыг өгсөөр байна. Сүүлийн үеийн судалгааны үр дүнгүүд нь амьтны хүрээлэн, байгаль дахь бодгалиудын генетикийн дээж дээр суурилан цоохор ирвэсний геномыг хөгжүүлж байна.

Цоохор ирвэсийг судалгаа, хамгаалал, хүн зэрлэг амьтны зэрэгцэн оршин тогтноход гарч буй бэрхшээл зэргээс үүдэн шилжүүлэн суурьшуулах ёсгүй гэдэг дээр дэлхийн эрдэмтэд, байгаль хамгааллын салбарынхан нэгэн дуугаар санал нэгдэж байна. Цоохор ирвэсийг өөрийн амьдрах орчноос нь өөр газарт нутагшуулах, зөөвөрлөх нь олон зөрчилдөөнийг орон нутагт үүсгэж болзошгүй тул аль болох байгальд нь суллан тавих бүхий л хүчин чармайлт гаргахыг зөвлөж байна. Ингэснээр орон нутгийнханы байгальдаа эзэн байх сэтгэлгээг дэмжин цаашид гарч болзошгүй эрсдэлийг бууруулах юм.

Шилжүүлэн суурьшуулах үйлдлийг боломжит ямар ч арга замгүй болсон үед хийгдэх хамгийн эцсийн арга гэж үзвэл зохилтой. Дэлхийн амьтны хүрээлэнгүүдэд нилээдгүй цоохор ирвэс байгаа ба үүнд бүс нутгийн болон олон улсын холбогдох байгууллагууд, Дэлхийн Аквариум болон Амьтны Хүрээлэнгийн Холбоо (WAZA) зэрэг байгууллагууд хяналт тавьж байна. Жишээлбэл, WAZA нь энэхүү зөөвөрлөгдсөн нэн ховор, ховор амьтдын популяцийг хянах үүрэгтэйгээс гадна мэдээллийн нэгдсэн санг хөтөлж байдаг. WAZA-ийн бодлогод амьтны хүрээлэнгийн цоохор ирвэсний популяцийн тоо толгой 450 орчим бодгаль байдаг тул хөдлөлзүй болон генетик олон янз байдлаар энэхүү амьтныг амьдрах орчноос нь барих шаардлагагүй хэмээн тусгасан байна. Энэ тоо нь байгальд буй төрөл зүйлийн устах аюулд хүргэж болзошгүй ямар нэгэн массыг хамарсан үхлийн эрсдэлээс үүдэн гарсан хүчин зүйлийг даван туулахад хангалттай тоо хэмээн үзсэн. Цоохор ирвэс тархсан ихэнх орнуудад шилжин суурьшуулсан амьтдыг тэжээх, байршуулах амьтны хүрээлэн, асран хамгаалах төвүүд, сэргээн нутагшуулах газрууд байдаг.

Цоохор ирвэс нь Азийн өндөр уулс болох өөрийн амьдрах орчиндоо чөлөөтэй амьдрах эрхтэй. Зайлшгүй онцгой тохиолдлоос бусад үед цоохор ирвэсийг шилжүүлэн суурьшуулах, барьж тэжээх нь ёс зүйгүй үйлдэл бөгөөд шинжлэх ухааны болон байгаль хамгаалах зорилгод ч үл нийцнэ.

Цоохор ирвэсний сүлжээ нь цоохор ирвэсийг хамгаалах зорилгоор дэлхийн өнцөг булан бүрийн хүмүүсийн мэдлэг, мэдээлэл солилцоход чиглэгдсэн дэлхий хэмжээний байгууллага юм.

Цоохор ирвэсний сүлжээний эрхэм зорилго бол хувь хүмүүс, байгууллага, засгийн газруудын хоорондын холбоо, хамтын ажиллагааны тусламжтайгаар ховордсон цоохор ирвэсийг шинжлэх ухааны үндэслэлтэй хамгаалахад дэмжлэг үзүүлэх явдал юм.

Энэхүү мэдэгдлийг гаргасан Олон Улсын Цоохор Ирвэс Сүлжээний Зөвлөл:

- Профессор Сандро Ловари (Зөвлөлийн дарга)
 - Белинда Райт (Зөвлөлийн гишүүн)
 - Доктор Мадху Четри (Зөвлөлийн гишүүн)
 - Лхагважавын Пүрэвжав (Зөвлөлийн гишүүн)
 - Доктор Шиао Линюн (Зөвлөлийн гишүүн)
 - Вали Модаккик (Зөвлөлийн гишүүн)
 - Доктор Орьян Жоханссон (Зөвлөлийн гишүүн)
 - Доктор Жастин Шанти Александр (ИХС-ний Гүйцэтгэх захирал, зөвлөлийн гишүүн)
-